



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗАР ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 08 сарын 30 өдөр

Дугаар 6/95

Мандалговь

Б.Түвшинжаргалыг албанаас чөлөөлж,
цол хураан, шилжүүлэх тухай

Монгол Улсын "Төрийн албаны тухай хууль"-ийн 46 дугаар зүйлийн 46.1.2, Засгийн газрын 2017 оны 72 дугаар тогтоолоор батлагдсан "Цагдаагийн бага, дунд, ахлах цол олгох бууруулах, хураан авах, сэргээх журам"-ын 5 дугаар зүйлийн 5.2.6, Цагдаагийн Ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар батлагдсан "Байгууллагын даргын тушаал гаргах" /код-136/ 136 журмын 136.5.2-ын 2"г", мөн даргын 2019 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн Б/676 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хууль зүйн сайдын 2016 оны А/146 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Цагдаагийн мэргэшсэн алба хаагч бэлтгэх, мэргэшлийг дээшлүүлэх хөтөлбөр"-ийн хүрээнд бүрэн дунд боловсролын түвшингийн 2.5+/2/+1.5 жилийн сургалтад хамрагдсан Эрүүлжүүлэх саатуулах байрны жижүүрийн цагдаа, цагдаагийн дэд ахлагч Б.Түвшинжаргалыг энэ оны 08 дугаар сарын 30-ны өдрөөр тасалбар болгон албанаас чөлөөлж, цагдаагийн дэд ахлагч цолыг хураан, үргэлжлүүлэн суралцуулахаар Дотоод хэргийн их сургуулийн мэдэлд шилжүүлсүгэй.

2.Б.Түвшинжаргалын ажлыг хүлээлцүүлж, үнэмлэх энгэрийн тэмдгийн тооцоо хийхийг Хүний нөөцийн мэргэжилтэн, /цагдаагийн дэслэгч Е.Алтанзул/-д, Сургалтын гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, /цагдаагийн хошууч Т.Розон/-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга, /цагдаагийн дэд хурандаа Л.Баярсайхан/-д даалгасугай.

ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА

О.АМАРСАНАА

Хуулбар үнэн:

Захиргааны удирдлагын тасгийн дарга,
цагдаагийн дэд хурандаа

Л.Баярсайхан

40003860



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗАР ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 08 сарын 30 өдөр

Дугаар 5/96

Мандалговь

Сургалтад суралцуулах
чөлөө олгох тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.7 дахь заалт, Цагдаагийн Ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар батлагдсан "Байгууллагын даргын тушаал гаргах" журам /код-136/ 136.5.2-ийн "г", мөн даргын 2019 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 6/656 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус цагдаагийн газрын Мэдээлэл хүлээн авагч, жижүүрийн цагдаа, цагдаагийн ахлагч Эрдэнэбатын Ванчиндорж Дотоод хэргийн их сургуулийн "Цагдаагийн ажил-эрх зүй" эчнээ сургалтад 2019 оны 09 дүгээр сарын 02-ны өдрөөс 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийг хүртэл хугацаанд сургалтад суралцуулж чөлөө олгосугай.

2. Цагдаагийн ахлагч Э.Ванчиндоржийн цалинг зохих журмын дагуу бодож олгохыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн ахмад Ц.Нарантогос/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА, ЦАГДААГИЙН
ХУРАНДАА

О.АМАРСАНАА

Хуулбар үнэн:

Захиргааны удирдлагын тасгийн дарга,
цагдаагийн дэд хурандаа

Л.Баярсайхан



40003651



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗАР ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 09 сарын 26 өдөр

Дугаар 6/96

Мандалговь

Цалинтай чөлөө
олгох тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1 дэх хэсэг, Цагдаагийн Ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар батлагдсан "Байгууллагын даргын тушаал гаргах" журам /код-136/ 136.5.2-ийн "г", мөн даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар батлагдсан "Алба хаагчид чөлөө олгох" журам /код 934/-ын 934.2.3-ын "б", "в", "д"-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дэрэн сум дахь хэсгийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч С.Энхтүвшингийн ээж Ш.Светлана нь өвчний учир биеийн байдал муудсан гэх тул 2019.09.13-ны өдрөөс 2019.09.24-ний өдрийг дуустал ажлын 8 хоног, Улаанбаатар хот явах хувийн чөлөө хүссэн хэсгийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч С.Бүргэдэд 2019.09.16-ны өдрөөс 2019.09.18-ны өдрийг дуустал ажлын 3 хоног, Зөрчлийн тоо бүртгэгч, цагдаагийн ахлах ахлагч М.Болортуяад 2019.09.13-ны өдрийн ажлын 1 хоног, эргүүлийн цагдаа, цагдаагийн дэд ахлагч О.Бүрэнбатад 2019.09.26-ны өдрөөс 2019.09.27-ны өдрийг дуустал ажлын 2 хоног, цагдаа жолооч, цагдаагийн ахлах ахлагч Б.Болордуулгад 2019.09.23-ны өдрөөс 2019.09.30-ны өдрийг дуустал ажлын 6 хоногийн цалинтай чөлөөг тус тус олгосугай.

2. Алба хаагчдын цалинг зохих журмын дагуу бодож олгохыг Ахлах нягтлан бодогч /цагдаагийн ахмад Ц.Нарантогос/-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хувийг алба хаагчдын хувийн хэрэгт хийхийг Хүний нөөцийн мэргэжилтэн /цагдаагийн дэслэгч Е.Алтанзул/, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга, /цагдаагийн дэд хурандаа Л.Баярсайхан/ нарт тус тус үүрэг болгосугай.



ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА

О.АМАРСАНАА

Хуулбар үнэн:

Захиргааны удирдлагын тасгийн дарга,
цагдаагийн дэд хурандаа

Л.Баярсайхан



40003604



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗАР ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 09 сарын 21 өдөр

Дугаар 67/20

Мандалговь

Алба хаагчдын цалинг
нэмж, бууруулж олгох тухай

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар батлагдсан "Байгууллагын даргын тушаал гаргах" журам /код-136/ 136.4.2-ийн "в", "Алба хаагчийн ажлыг үнэлэх" журам /код-111/, 111.4.2, Цагдаагийн газрын даргын 2016 оны 6/19 дүгээр тушаалаар батлагдсан "Ажил дүгнэх журам"-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.2019 оны 09 дүгээр сард үндсэн үүргээ хангалттай сайн гүйцэтгэсэн нэр бүхий алба хаагчдын цалинг нэг сарын үндсэн цалингийн заасан хувиар нэмж олгосугай. Үүнд:

1. д/х Л.Баярсайхан	20	11. а/д Л.Батбаяр	10
2. а/х Н.Ганбат	20	12. а/д З.Жаргал	10
3. х/ч Ш.Цэндбаатар	20	13. а/д Д.Цогт-Очир	10
4. а/х Б.Мягмарсүрэн	20	14. а/а Ш.Ууганбаяр	10
5. а/а Б.Сугирдорж	20	15. а/а Х.Энэбиш	10
6. д/х Ж.Жавзандулам	15	16. а/а Д.Мөнхбаатар	10
7. а/х Б.Гантуяа	15	17. а/а Г.Чагнаадорж	5
8. х/ч Т.Ганбаяр	10	18. а/ч М.Зандраа	5
9. а/х Г.Хатанбаатар	10	19. д/а О.Бүрэнбат	5
10. а/х Д.Баттулга	10	20. д/а Д.Чимэддорж	5

2.2019 оны 09 дүгээр сард үндсэн болон нийтлэг үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн доорхи алба хаагчдын цалинг нэг сарын үндсэн цалингийн заасан хувиар бууруулж олгосугай. Үүнд:

1. д/а Х.Хаянхярваа	20	6. а/д М.Бат-Эрдэнэ	10
2. а/а Ч.Эрдэнэбулган	15	7. а/х Х.Амарзаяа	10
3. а/ч Б.Ариунболд	15	8. д/ч С.Батбаяр	10
4. д/а А.Батзориг	15	9. д/ч Т.Адъяабат	10
5. д/а Б.Цэндсүрэн	15	10. а/а С.Бүргэд	10

3.Цагдаагийн газрын дотоод журмын 2.2-д заасны дагуу нөхцөл байдлаа илтгээгүй, өглөөний рапорт, түргэн цугларалт тасалсан, эзлж хүлээлцэхэд ирээгүй нэр бүхий алба хаагчдын цалинг нэг сарын үндсэн цалингийн заасан хувиар бууруулж олгосугай. Үүнд:

1. д/а Д.Чимэддорж	4	5. а/а Г.Чагнаадорж	2
2. а/х Б.Мягмаррагчаа	2	6. а/ч Т.Чинзориг	2
3. х/ч М.Уламбаярлах	2	7. д/а А.Батзориг	4
4. а/д М.Батболд	2	8. а/ч Ш.Жавхлантөгс	2

40003609

9. а/ч Д.Мөнхбаатар 2
10. д/а Б.Золжаргал 2
11. д/а Б.Баасансугир 2

12. д/а Б.Азжаргал 2
13. д/а Х.Хаянхярваа 2

4. Дээрхи нэр бүхий алба хаагчдын цалингийн хэмжээг 2019 оны 09 дүгээр сард бууруулж олгохыг ахлах нягтлан бодогч, /цагдаагийн ахмад Ц.Нарантогос/- д зөвшөөрсүгэй

ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА

О.АМАРСАНАА

Хуулбар үнэн:

Захиргааны удирдлагын тасгийн дарга,
цагдаагийн дэд хурандаа

Л.Баярсайхан



